

ГАМШГИЙН ҮЕИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

М.ХОНГОРЗУЛ¹, Ш.БОЛДБААТАР²

¹ДХИС-ийн АШБС-ийн “Гамшиг судлал”-ын магистрант

²Удирдагч багш, Доктор (Ph.D), хурандаа,

Товч агуулга

Хэвлэл, мэдээллийн талаарх онол, арга зүйг судалж, гамшгийн эрсдэлийг бууруулах, иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн аюул, осол тохиолдсон үед хэвлэл, мэдээллийн эрх зүйн зохицуулалт, цаашид олон нийтэд гамшгийн үеийн мэдээллийг түгээх байдлыг судалж, тодорхойлохыг зорилоо.


Түлхүүр үг: Хэвлэл мэдээлэл, гамшиг, эрх зүйн зохицуулалт, олон нийт, гамшгийн эрсдэлийг бууруулах

Оршил

Телевиз радиогийн мэдээллийн нэвтрүүлэг нь олон нийтэд гамшгийн үеийн хэрэгцээтэй мэдээллийг гамшгийн менежментийн бүхий л үе шатанд нь дамжуулж хүргэх суваг, арга зам болохоос гадна иргэд олон нийт гамшгийн талаарх мэдлэг, ойлголт олж авах гол хэрэгсэл болдог. Хэвлэл мэдээллийн байгууллага нь төр, олон нийтийн үйл ажиллагаанд хувь нэмэр болж, тэнцвэртэй байдлыг хадгалах ач холбогдолтой эсвэл ач холбогдолгүй байх талтай байдаг¹.

Гамшгийн үеийн хэвлэл мэдээлэл

Гамшгийн үеийн хэвлэл мэдээллийн талаарх олон судалгаанаас харахад хамарч байгаа мэдээний агуулгын үнэн зөв байхад, магадгүй ямар нэгэн зүйлийг орхигдуулах байхад илүү анхаардаг. Дамжуулж буй мэдээний хувьд нэн даруй шийдвэрлэвэл зохих санаа зовоосон асуудал болон түүнд иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжихийг хамруулж хэвлэл мэдээллээр үзүүлж харуулах нь магадгүй хамгийн чухал зүйл байж болох юм. (Dynes 1998, 114). Гэвч гамшгийн үед гадаад орнуудын болон манай орны зарим телевиз радио сонин хэвлэл, зар сурталчилгааны нийтлэлд гамшгийн үед авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэн бодит байдлыг мэдээлэхийн оронд санаатайгаар ул үндэслэлгүй шуугиан дэгдээх, бизнесийн ашиг олох зорилгоор хүний нэр төрийг гутаах, онцгой байдлын албаны дүр төрхийг сөргөөр илэрхийлэх явдал заримдаа гардаг байна.



Зураг 2. Гамшгийн телевизийн үүрэг²



Түүнчлэн хэвлэл мэдээлэл нь олон нийт болон Онцгой байдлын байгууллагуудын хооронд харилцаа холбоо тогтоох замаар гамшгийн өмнө, гамшгийн үед гамшгийн дараах үе шатанд амин чухал мэдээллийг олон нийтэд түгээхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хэвлэл мэдээлэл нь хүн амд гамшгийн талаарх мэдлэг олгох, аюулын тухай зарлан мэдээлэх, гамшгийн хөнөөлийн голомтын тухай мэдээллийг цуглуулж түгээх, засгийн газрын болон хандив тусламжийн байгууллагын албан тушаалтнууд хүн амыг дохиогоор бэлэн байдал оруулж онцлог хэрэгцээг тодорхойлох, гамшгийн бэлэн байдлыг хангах болон хариу арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайжруулах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулахад туслах зэргээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бодиттой дэмжлэг үзүүлэх боломжтой байдаг. Хэвлэл мэдээллийнхний мэдээ мэдээлэл нь орон нутгийн иргэдэд гамшгийн талаарх мэдлэг олгоход найдвартай гүүр болж өгдөг. Телевиз, радио, болон хэвлэл тараах материал нь иргэд олон нийт гамшгийн тухай мэдлэгийг хэрхэн яаж олж авч суралцах хэрэгцээг хангах мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, дамжуулах суваг, арга зам болдог.

Хэвлэл мэдээллийн байгууллага/ телевизийн мэдээлэл нь үнэн зөв мэдээллийг хэрэгтэй цаг хугацаанд гамшигт нэрвэгдсэн хүн амд хүргэхээс гадна тэдэнд хүнд бэрх нөхцөл байдлын үед эв нэгдэл, итгэл найдвар төрүүлэх уур амьсгалыг бий болгох үүрэг зорилготой байх ёстой. Ингэснээр аливаа гамшгийн улмаас үүссэн хүнд бэрх асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн бүхий л давхарга, салбаруудын хамтын хүчин чармайлт, хариуцлагыг бэхжүүлэхэд туслах болно.³

Гамшгийн үеийн мэдээлэл нь мэдээллийн хэрэгцээ, хэвлэл мэдээллийнхний анхаарлаа төвлөрүүлэх хэрэгцээ, дадлага сургалтын хэрэгцээ болон төлөөлөлтэй байх хэрэгцээ зэргээс бүрддэг.

Байгалийн гамшигт нэрвэгдэгсэд нь 4 төрлийн хэвлэл мэдээллийнхний хэрэгцээтэй байдаг.

Нэгдүгээрт, мэдээллийн хэрэгцээ. Нэрвэгдэгсэд нь агуулгын хувьд баялаг, практик амьдралд ойрхон амин чухал мэдээллүүдийг хэвлэл мэдээллийн болон хэвлэл мэдээллийн бус шугамаар олж авахад хүчин чармайлт гаргадаг. Нэрвэгдэгсэд нь хэвлэл мэдээллийнхэн тухайн нөхцөл байдалд үндэслэсэн, асуудалд шүүмжлэлтэй хандсан, үнэ зөв, нэн шаардлагатай мэдээллээр хангана гэсэн хүлээлттэй байдаг.

Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн анхаарлын төвд байх хэрэгцээ. Нэрвэгдэгсэд нь тэдгээрийн өмнө тулгарсан бэрхшээлтэй асуудлууд, зовлон шаналал, хэрэгцээнд тусгайлан анхаарч, цаг үргэлж халуун дотно хандан хамгаалж, тэдэнд тусламж дэмжлэг үзүүлж байгааг орон нутгийн болон үндэсний телевизүүдээр нэвтрүүлэхийг хүсдэг. Нэрвэгдэгсэд нь хэвлэл мэдээллийн анхаарлын төвд байх нь тусламж дэмжлэг үзүүлэх хүмүүсийн болон эрх баригчдын анхаарлыг татах, нэрвэгдэгсдийн сэтгэл санааг тайвшруулах, сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлж нөхцөл байдлыг намжаах, хэвлэл мэдээллийнхэнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тэднийг аливаа хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхэд тус нэмэр болдог.

Гуравдугаарт, гамшгийн өмнө болон гамшгийн дараах үеийн дадлага сургалтын хэрэгцээ юм. Тэдгээр нь болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл орон нутагт тохиолдохоос өмнө телевиз үзэгчдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх сэдвээр өргөн хүрээтэй агуулга бүхий сургалтыг тасралтгүй нэвтрүүлэхийг орон нутгийн хэвлэл мэдээллийнхнээс хүсдэг. Түүнчлэн гамшгийн дараах нэрвэгдэгсдийн хэрэгцээнд тулгуурласан зарим сургалтын агуулга нь цөөнхийн бүлэг болон шинжээчдэд зориулагдсан ирээдүйд тохиолдож болох аюулт үзэгдэл, гамшгаас хамгаалах зорилго, практик ач холбогдол бүхий.

Дөрөвдүгээрт, гамшигт нэрвэгдэгсэд нь өөрсдийгөө төлөөлөх төлөөлөлтэй байхыг хүсдэг хэрэгцээ юм. Тэдгээр нь нэрвэгдэгсдийн нэрийн өмнөөс хямралт байдлыг зохицуулах менежментийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрх баригчдын амласан амлалт, тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж байгааг мэдэж байхыг хүсдэг. Тэдгээрийг төлөөлж буй этгээдийн хувьд, нэрвэгдэгсэд нь хэвлэл мэдээллийнхнийг тэдний хүс ч байгаа зүйлүүд, хэрэгцээ болон тухайн гамшгийн нөхцөлд байдал, эрхээ хамгаалуулах шаардлагын талаар хямралт байдлыг зохицуулах үүрэг бүхий онцгой байдлын албаны удирдлагуудад мэдээлж байхыг хүсдэг.

Хоёр. Гамшгийн үеийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт

Эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг түүнийг хэрэгжүүлэхэд хууль болон бусад дүрэм, журам гэсэн гурван чиглэлээр хийлээ. Үүнд:

1. Бодлогын баримт бичиг

а. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”⁴-ийн 3.3-т “Дотоод аюулгүй байдал- Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.” гэж ерөнхийлөн тусгасан.

б. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс.

“Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”⁵ ийн 8.3.13-т “Батлан хамгаалах мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох; гэж тусгасан.

в. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого.

“Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”⁶-ын үндсэн чиглэлийн 2.4-т “Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулна.” гэж тус тус заасан.

г. Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого.

“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”⁷-ын нийтлэг үндэслэлийн 1.1-т “Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх чиглэлээр 1999-2016 онд “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл

хөгжүүлэх үзэл баримтлал” (1999-2010), “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” (2002-2006), “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр (2005-2012), “Цахим засаг” үндэсний хөтөлбөр (2012-2016), “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2010-2015), “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр” (2011-2015) зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг батлан үндсэнд нь амжилттай хэрэгжүүлээд байна. Үүний үр дүнд манай улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагаа давамгайлж, хувьчлал, зах зээлийн либералчлал, өрсөлдөөнийг дэмжих бодлого тууштай хэрэгжин тус салбарын үр ашиг, орлого өсч, өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 2.4 хувийг эзэлж байна. Түүнчлэн улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар, иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэвшилтэт технологи нэвтэрч, өдөр тутмын хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааных нь салшгүй хэсэг болсон байна.

Цаашид мэдээлэл, харилцаа холбооны зөөлөн болон хатуу дэд бүтэц, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, инновацид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тус салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх, өндөр ур чадвар бүхий мэргэжилтэн, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн болон программ хангамжийн кластер байгуулах зэрэг асуудал тулгарч байна. Иймд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийгмийн харилцаа, хүмүүсийн өдөр тутмын амьдралд үзүүлэх бодит эерэг нөлөө болон олон улс, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тухайн салбарын улс орны эдийн засаг, нийгмийн бусад салбар, олон талт харилцаанд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд мэдээлэл, харилцаа холбооны салбарыг цаашид хөгжүүлэх бодлогыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх тодорхой зорилт тусгагдсан нь төрөөс баримтлах энэхүү бодлогыг боловсруулах үндэслэл болж байна. Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогыг баталж хэрэгжүүлснээр мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийг дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэх, цахим засгийг хөгжүүлэх, бусад салбарын үйл ажиллагааг цахимжуулах, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, цаг алдалгүй шуурхай хүргэх зэрэг үр дүн гарах юм.” гэж тус тус заасан.

2. Монгол Улсын хуулиуд.

а. Монгол Улсын Үндсэн хууль

“Монгол Улсын Үндсэн хууль”⁸-ийн арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, 16-т “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”, 17-т “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж,

б. Гамшгаас хамгаалах тухай хууль

“Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 10.5-т “Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.”, 16.2-т “Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах,

холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана.”, 16.3-т “Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.”, 16.4-т “Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын байгууллага гүйцэтгэнэ.”, 16.5-т “Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журмыг Засгийн газар батална.”, 29.1.5-т “гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах,” гэж,

в. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”⁹-ийн хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй. Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэж,

г. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль

“Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль”¹⁰-ийн 15.2.-т “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.” гэж,

г. Олон нийтийн радио телевизийн тухай хууль

“Олон нийтийн радио телевизийн тухай хууль”¹¹-ийн 3.1-т “Олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн.”, 3.2-т “Олон нийтийн радио, телевизийн зорилго нь үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход оршино.” гэж,

д. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль

“Өргөн нэвтрүүлгийн тухай хууль”¹²-ийн 24.4-т “Онц байдал зарласан, эсхүл гамшгийн үеийн нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлж үл болно”, 29.1.3-т “өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам боловсруулж, батлах,” гэж,

е. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” 13-ийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж,

ё. Эрүүгийн хууль

“Эрүүгийн хууль”¹⁴-ийн 13.14 дүгээр зүйлийн Худал мэдээлэл тараах бүлгийн 1-т “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт

худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”, гэж,

ж. Иргэний хууль

“Иргэний хууль” 15 -ийн 21 дүгээр зүйлийн Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах бүлгийн 21.1-т “Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно.”, 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.”, 21.3-т “Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ.” 21.4-т “Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.” 21.7-т “Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.” гэж тус тус тусгасан байна.

з. Дүрэм, журам.

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралтаар “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж, тус төлөвлөгөөнд “Хэвлэл мэдээллийн байгууллагаар зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх”, “Гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах” асуудлыг удирдан чиглүүлэх үүргийг Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба” гэж,

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын хавсралтаар “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ын 4.1.1-т “төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэдийг дайчлах, гамшгийн хор уршгийг арилгасан үед дайчилгааг цуцлах тухай шийдвэрийг гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;” гэж,

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар “Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 2.1.6-т “гамшгийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх, бий болсон нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагуудын шуурхай албад, аймаг нийслэл, орон нутгаас ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, эрх бүхий байгууллага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж тэдгээрийг бодит мэдээллээр хангах. Үүнд: -Ердийн үед Засгийн газрын шуурхай мэдээллийн алба өдөр тутмын мэдээллийг яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн шуурхай албад, жижүүрээс хүлээн авч нэгтгэн Улсын онцгой комиссын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шуурхай мэдээллийн албанд холбоо, мэдээллийн техник хэрэгслээр болон бичгээр танилцуулна. Засгийн газрын бусад гишүүдэд цахим сүлжээгээр дамжуулан хүргэнэ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шуурхай мэдээллийн алба нь дагаж мөрдөж байгаа журам, зааврын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд болон ажлын албанд танилцуулна; Онцгой нөхцөл байдал үүссэн үед бүх мэдээллийг Улсын онцгой комиссын ажлын алба нэгтгэн дүгнэж, удирдлагыг нэг цэгийн шуурхай мэдээллээр тухай бүр хангаж нөхцөл байдлын талаар хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэдэд мэдээлэх ажлыг хариуцна.”, 2.1.9-т “комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар

хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх;”, 2.2.7-т “комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу оролцуулах” гэж,

Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 276 дугаар тогтоолын хавсралт “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл”-ийн 10-т “10. Онцгой байдал үүссэн нөхцөлд шаардлагатай зар, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, шуурхай хүргэх асуудлыг зохицуулах” гэж,

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 303 дугаар тогтоолын хавсралт “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.9-т “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг тодорхой давтамжтайгаар нийтэд түгээх;” гэж тус тус тодорхой тусгасан байна.

Дүгнэлт, санал

Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Дэлхийн олон улсын баримт бичгүүд болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх талаар гаргасан Тунхаг бичиг, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2005 онд Япон Улсын Хөого хотноо зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан “2005-2015 онд улс үндэстэн орон нутгийн гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх Хөогогийн үйл ажиллагааны хүрээ”-ний тунхаг бичигт “... орон нутгийн ард иргэдийг эрсдэлийн үнэлгээ хийх, бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, эрт зарлан мэдээлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, мэдээлэл сурталчилгаанд өргөн хүрээтэй хамруулах”¹⁶ гэж заасан бөгөөд мөн тус байгууллагаас 2015 онд Япон Улсын Сендай хотноо зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан “2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт¹⁷ “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь: үндэсний эрх бүхий байгууллагуудтай нягт хамтран орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын бүх түвшинд олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэл, аюул, гамшгийн талаарх олон нийтэд зориулсан үнэн бодит мэдээллийг энгийн, нээлттэй, ойлгоход хялбар, хүртээмжтэй байдлаар түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй оролцох”¹⁸ гэж тусгасан билээ.

Гамшгийн үеийн мэдээ, мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллагын гүйцэтгэх үүргийг “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 16.3-д “Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй”, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.9-д “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг тодорхой давтамжтайгаар нийтэд түгээх”¹⁹ гэж тодорхой тусгаж өгсөн байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийн УИХ –д өргөн барьсан байдаг”²⁰. Тус хуулийн төслийн 23.4.-д “Гамшгийн болон онцгой байдал, урьдчилсан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журмыг дагаж мөрдөнө” гэж заажээ.²¹

Дээрх хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлан үзэхэд гамшгийн үеийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт хангалттай байна.

Харин олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг тодорхой давтамжтайгаар нийтэд түгээх байдлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Ш.Болдбаатар байгалийн гамшиг ба хэвлэл мэдээлэл, УБ хот, 1998 он, х-40-41.
2. Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, УБ хот, 2011 он. Төрийн мэдээллийн эмхтгэл, дугаар
3. “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
4. Төрийн мэдээллийн эмхтгэл, УБ хот, 2017 он дугаар.
5. Ник Картер, Гамшгийн менежмент. УБ хот, 2006 он, х-229.
6. Н.Болормаа, Телевизийн мэдээллийн нэвтрүүлэг, Өнөөгийн байдал цаашдын хөгжлийн чиг хандлага, УБ хот, 2018 он.х-33.
7. Төрийн мэдээллийн эмхтгэл,
8. Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл батлах тухай” Дугаар 276 тогтоол.
9. Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр,
10. Lankford, Darrell M. 1998. “Working with the Media During a Crisis.” NCCEM Bulletin 15, No. 1 (January): 6–7.
11. Ник Картер, Гамшгийн менежмент. УБ хот, 2006 он, х-241-242.
12. Lankford, Darrell M. 1998. “Working with the Media During a Crisis.” NCCEM Bulletin 15.
13. Ш.Болдбаатар нар, Гамшгаас хамгаалах цагаан ном, УБ хот, 2017, х- 40
14. Ц.Мөнхсүх, Телевизийн зах зээлийн үнэлгээнд хөгжлийн чиг хандлага, судалгааны ажил, УБ хот, 2017 он.
15. М.Мөнхмандахнар, Хэвлэл мэдээлэл, хэрэглэгчдийн судалгаа, Хэвлэлийн Хүрээлэн, УБ хот, 2015 он.
16. <https://www.unisdr.org/we/coordinate/hfa>
17. <https://www.unisdr.org/we/coordinate/sendai-framework>
18. <https://www.legalinfo.mn/law/details/367>
19. <https://www.legalinfo.mn/law/details/6163>
20. <https://www.legalinfo.mn/annex/details/3371?lawid=5909>
21. <https://www.legalinfo.mn/annex/details/3357?lawid=6709>
22. <https://en.unesco.org/news/disaster-risk-reduction-invest-today-safer-tomorrow>
23. <https://www.fema.gov/media-library-data>, Natural hazard mitigation saves: 2017 interim report
24. https://www.academia.edu/8070343/ROLE_OF_MEDIA_IN_DISASTER_MANAGEMENT
25. https://emergency.cdc.gov/cerc/cerccorner/article_031517.asp
26. www.Role-of-media-in-disasters-Asim-Raza.
27. https://www.academia.edu/8070343/ROLE_OF_MEDIA_IN_DISASTER_MANAGEMENT
28. <https://www.legalinfo.mn/law/details/11634>
29. <https://www.legalinfo.mn/law/details/299>
30. www.parlament.mn;
31. <http://www.globeinter.org.mn/>
32. <https://www.legalinfo.mn/law/details/424>
33. <https://www.legalinfo.mn/law/details/259>